



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 23

№ 01/52 ДУА-2018/26/СТА-ТЦЗ Мандалговь хот

Г

Г

**Зөрчил арилгуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар ээлжийн амралттай байх хугацаанд тасралтгүй ажиллагааг хангаж, орлон гүйцэтгэх эрх, үндэслэл хангахгүй сайдын тушаалаар **1,627,826.00 /нэг сая зургаан зуун хорин болоон мянга найман зуун хорин зургаан/** төгрөгийн цалинг гэрээт ажилтанд олгож, давхардуулан илүү зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/-т, мөн 16 дугаар зүйлийн 16.5.3 /батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох/ Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-т /Ажилтанд ээлжийн амралтын хугацаанд ээлжийн амралтын олговор олгоно/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.5-т /Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага нөхцөлийг хангаагүй/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:


1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга Я.Мажаасүрэн, нягтлан бодогч Р.Мөнхсүрэн нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:  
АХЛАХ АУДИТОР  Т.БАТСАЙХАН



ЗӨВШӨӨРСӨН:  
ДАРГА  Я.МАЖААСҮРЭН  
НЯГТЛАН БОДОГЧ Р.МӨНХСҮРЭН



<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зорчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/